

**ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА,
ОРОН СУДЛАЛ**

ИХ ГҮРНИЙ ОНЦОЛЖ БУЙ ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА

Д. Долгосүрэн*

Улс гүрнүүд эрт үеэс аюулгүй байдлаа хангах зорилгоор цэрэг, зэвсэг буюу “хатуу хүч”-ийг хэрэглэж ирсэн билээ. Даяаршлын өнөө үед дан ганц хатуу хүчийг хэрэглэвэл олон улсын тавцанд ганцаардах, янз бүрийн хориг арга хэмжээнд орох, улсын бодлого нь иргэдэд нь шууд болон шууд бусаар нөлөөлөх зэрэг сөрөг үр дагавартай учраас “зөөлөн хүч” болох соёлын болон олон нийтийн дипломат ажиллагааг өргөнөөр хэрэглэж аюулгүй байдлаа хангахыг хичээх болжээ. Дэлхий даяаршиж, эгэл хүний асуудал ч энэ дэлхийн хувь заяатай холбогдох болсон эрин үед хүн төрөлхтөн аж төрж байна. Олон улсын харилцаа ойртон нягтарсан энэ үед аль нэг улс оронд гарсан хямрал, үймээн самуун нь зөвхөн тэр улсдаа бус, хөрш орнуудад, цаашлаад бүс нутаг, дэлхий нийтэд ч нөлөөлдөг болжээ.

XX зууны дунд үеэс идэвхжиж, олон улсын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэх болсон шинэ дипломат ажиллагааны нэг том төрөл олон нийтийн дипломат ажиллагааг онолын болоод түүхэн үүднээс судлах нь чухалд тооцогдож, сонирхлыг татсан ‘судалгааны сэдэв болоод байна. Тиймээс өнөөгийн олон улсын харилцаанд глобал шинжтэй болж буй “олон нийтийн дипломат ажиллагаа” гэдэг ухагдахууныг онол практикийн талаас нь судалж, ач холбогдлыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны өгүүллийг бичлээ.

Олон улсын харилцаанд оролцогч улсуудын өөр хоорондын харилцаа, хамтын ажиллагааг илэрхийлдэг, мөн *аливаа улсын гадаад бодлогоо хэрэгжүүлэх, энгийнээр хэлбэл бусад улстай харилцах харилцааг яриа хэлэлцээрийн арга замаар зохицуулах арга ажиллагаа*¹ болох дипломат ажиллагаа нь уламжлалт, сонгодог хэв маягаасаа өөрчлөгдөж, орчин үеийн дэлхий ертөнцийн нөхцөл байдлаас шалтгаалан олон янзын хэлбэр төрхтэй болж байна. Тэгэхдээ, улс орнуудын засгийн газар хоорондын, өөрөөр хэлбэл улс түмний хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өрнүүлэх, бэхжүүлэх; үзэл бодол, мэдээллийг дамжуулах; байр сууриа харилцан илэрхийлэх;

* МУИС-ийн ахлах багш, докторант

1 J. C. Johari, “International Relations and Politics” (Theoretical Perspective in the Post-Cold War Era), New Delhi, Third edition, 2009; p. 476

үндэсний язгуур эрх ашиг, сонирхлоо харилцан хамгаалахын тулд улс бүр бусдаас ялгаатай бодлого явуулдаг хэдий ч аливаа асуудлыг үндэсний эрх ашгаа бодолцон хэлэлцэн зохицуулах дипломат ажиллагааны яриа хэлэлцээний үндсэн үүрэг нь өөрчлөгдөөгүй хэвээрээ гэж хэлж болно.

Гадаад хэлийг эзэмшихэд сайн толь бичиг чухал байдаг шиг гадаад бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд ухаалаг дипломат ажиллагаа зайлшгүй хэрэгтэй билээ. Олон улсын нөхцөл байдалд гарч буй түүхэн үйл явцтай холбогдон дипломат ажиллагааны агуулга, хэлбэр, арга барилд нилээд өөрчлөлт гарч, цар хүрээ нь өргөжин тэлж байна. Гол төлөв язгууртан угсаатан, дээдсийн хүрээнд, төр засгийн газрын түвшинд нууцлаг шинж нь давамгайлж байсан дипломат ажиллагаа эдүгээ өөрчлөгдөн баяжиж, ил тод, олон ишт үзэл бодлыг эрхэмлэсэн, илүү чөлөөтэй, бүх нийтийг хамрах чиг хандлагатай боллоо. Ийнхүү уламжлалт дипломат ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн тэлэх, нийгмийн доторх ашиг сонирхлын бүлэглэлүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудын үзэл бодол, үүрэг нөлөөг дээшлүүлэх зорилготой олон нийтийн дипломат ажиллагааны арга хэлбэрийг орчин үеийн олон улсын харилцаанд ихээхэн анхаарч үзэх болжээ. Ялангуяа АНУ, ОХУ, БНХАУ, Их Британи зэрэг олон улсын харилцаанд голлон оролцогч, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч их гүрнүүд, мөн Франц, Япон, Нидерланд, БНСУ-д энэ дипломат ажиллагааг хариуцсан тусгай газар хэлтсүүдийг бий болгож, үйл ажиллагааг нь улам идэвхжүүлэн дэмжиж байна. Гэтэл манай улсад энэ талаар онол практикийн нэгдсэн ойлголт үгүй, бичсэн ном зохиол бараг үгүй байна.

Хамгийн зөв, оновчтой дипломат ажиллагаа гэгдэж буй олон нийтийн дипломат ажиллагаа нь олон түмнээр дамжуулан улс орнуудын харилцааг ойртуулж, тэдний дунд харилцан ойлголцол, итгэлцлийг бий болгох замаар гадаад бодлогын таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий дипломат ажиллагааны нэг хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, төр засгаас гадаад орнуудад явуулж буй бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нийгмийн доторх ашиг сонирхлын бүлэглэлүүд, төрийн бус олон нийтийн байгууллага, ард нийтийн оролцоог ашиглах, тэдэнтэй хамтран ажиллах замаар өөрийн орны гадаад бодлогыг дэлхийн улс гүрнүүдэд эерэгээр ойлгуулах, ард түмэнд нь зөв сэтгэгдэл төрүүлэх замаар Засгийн газарт нь нөлөөлж, ингэснээр улс хоорондын харилцаанд нааштай уур амьсгал буй болгох зорилготой дипломат ажиллагаа юм. Олон нийтийн дипломат

ажиллагааг улс төрийн, эдийн засгийн, соёлын гэх мэт дипломат ажиллагааны бусад хэлбэрүүдтэй хослон явуулбал илүү их үр дүнтэй, ач холбогдолтой байдаг.

Олон нийтийн дипломат ажиллагаа нь хэрэгжиж ирсэн цагаасаа хойш хэд хэдэн үе шатыг туулжээ. Энэ нь өмнөх үеийн уламжлалт дипломат ажиллагаанаас ялгаатай учраас тэр онцлогийг нь ойлгож мэдсэнээр Монгол улс гадаад бодлогоо хэрэгжүүлэх нэг чухал арга хэрэгслийг дипломат ажиллагаандаа нэвтрүүлэх боломжтой юм. Олон нийтийн дипломат ажиллагааг онцолж буй шалтгаануудаас дурьдвал:

Нэгдүгээрт: Олон нийтийн дипломат ажиллагаа нь нөлөө бүхий хувь хүн эсвэл байгууллагаар дамжуулан төр засгийн үйл ажиллагаанд болон жирийн иргэдийн аж амьдралд хүчтэй нөлөөлдөг бөгөөд тэдгээрийн хооронд богино хугацаанд урт настай харилцаа холбоо тогтоож батжуулдаг байна.

Хоёрдугаарт: Олон нийтийн дипломат ажиллагаа нь өнөө үед улс гүрнүүдийн гадаад бодлогод чухал байр суурийг нэгэнтээ эзлэх болсон бөгөөд үүнийг бусад төрлийн дипломат ажиллагаанаас илүү чухалд тооцож байна. Улмаар энэхүү дипломат ажиллагаа нь судлаачдын сонирхлыг татсан сэдэв болж, онол, түүхийн талаас судлах явдал эрчимжиж байна.

Гуравдугаарт: Олон нийтийн дипломат ажиллагаагаар дамжуулан дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүд өөрийн нэр хүнд, байр суурийг олон улсын тавцанд бэхжүүлж, улс орныхоо талаар эерэг, зөв ойлголтыг дэлхий нийтэд төрүүлж, тэр ойлголтыг батжуулан бэхжүүлэх арга замаар гадаад бодлогоо улсынхаа эрх ашгийн үүднээс хэрэгжүүлэх нэгэн арга хэрэгсэл болгож байгаа бөгөөд цаашдын хөгжилд улмаар үндэсний аюулгүй байдалд нь сайнаар нөлөөлөх чухал ач холбогдолтой гэж үзэн олон нийтийн дипломат ажиллагааг эрчимтэй судалж хэрэгжүүлж байна.

Олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгжүүлэх арвин туршлагатай улс орнуудад үүнийг онол практикийн түвшинд нарийвчлан судалж, эрдэм шинжилгээний бүтээлийг олноор нь туурвиж байна. АНУ-ын Николас Калл, Филипп Саяб, Алан Хенриксон, Жон Х. Браун, Жозеф Най, Брус Грегори, Жеймс Снайдар; Английн Жим Мөөрфи, Нидерландын Ян Меллисен, болон Хятадын Жиань Ван, Ли Зигуанг, Өмнөд Солонгосын Сүк Жон Ли, Японы Акико Фукушима, Индонезийн Ризал Сүкма, Тайваны Юн-Хан Чу зэрэг судлаач эрдэмтэд олон нийтийн дипломат ажиллагааг гадаад бодлого,

олон улсын харилцаа, бүс нутаг судлал болон даяаршилтай холбон судалж байна. Дээрх орны эрдэмтэд судалгааны ажлынхаа үр дүнг дээшлүүлэхийн тулд олон улсын хурал сипозиумыг хамтран зохион явуулж, олон нийтийн дипломат ажиллагааны талаарх Palgrave Macmillan Series in Global Public Diplomacy нэртэй эрдэм шинжилгээний цуврал бүтээлийг эрхлэн гаргаж байна.

Олон нийтийн дипломат ажиллагааг онолын болон түүхэн талаас нь судалж байгаа эрдэмтэд судлаачдын дундаас АНУ-ын судлаач Жозеф Най (Харвард), Жон Браун (Жоржтаун), Брүс Грегори (Жорж Вашингтон), Хятадын судлаач Жоу Чиньчан, Мо Жинвей (Цингхуа Их Сургууль), Энэтхэгийн Ж. С. Жохари, Английн Жим Мөөрфи, Нидерландын Клингендаял ОУХарилцааны Институтын Элен Хуйж, Олон Нийтийн Дипломат Ажиллагааны зөвлөлийн ерөнхийлөгч Моррис Е. Жейкобс нарыг онцлон дурьдах нь зүйтэй. Түүнчлэн, АНУ-ын Төрийн Департаментийн Олон Нийтийн Дипломат Ажиллагаа хариуцсан газар, Өмнөд Калифорны Их Сургуулийн “Олон нийтийн дипломат ажиллагааны төв”, Массачусетс мужийн Тафтсын Их сургуулийн салбар, Хууль зүй, Дипломат Ажиллагааны Флетчер Сургуулийн “Эдвард Р. Марроугийн нэрэмжит Олон Нийтийн Дипломат Ажиллагааны Төв”, Нидерландын ‘Clingendael’ Олон улсын харилцааны институт болон их сургуулиудын дэргэдэх олон нийтийн дипломат ажиллагааны талаарх судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилго бүхий мэргэжлийн байгууллага, институтууд энэ дипломат ажиллагааг судлах ажилд үлэмж хувь нэмэр оруулж байна.

Хуучин социалист гэгдэж байсан орнуудад дипломат ажиллагааг төдийлөн онцолж үздэггүй байсан учраас энэ талаар бичсэн ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, уншиж судлах материал монгол төдийгүй орос хэлээр ч тун бага ажээ. Монгол улсад төдийлөн судлагдаагүй байгаа олон нийтийн дипломат ажиллагааны талаар МУИС-ийн ОУХС-ийн багш, америк судлаач, доктор, профессор, Д. Цолмон судалж, 2009 онд хэвлүүлсэн *“Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс”* хамтын бүтээлдээ оруулсан байдаг. Тэрээр олон нийтийн (ардын) дипломат ажиллагааг *“Огт шинэ үзэгдэл бус, түүний элементүүд байсан. Ялангуяа ХХ зууны II дахь хагасаас олон нийтийн дипломат ажиллагаа идэвхжиж байгаа”* гээд засгийн газрын гадаад үйл ажиллагаанд олон түмэн үнэлэлт өгөх, санаа бодлоо тусгах, гадаад бодлогыг боловсруулахад олон нийтийн оролцоог ашиглаж, илүү нээлттэй, ардчилсан байдлаар хандахын чухлыг бүтээлдээ онцолжээ. Эрдэмтэн Д. Цолмон АНУ-ын олон

нийтийн дипломат ажиллагааны үүсэл хөгжлийг гадаад бодлоготой нь уялдуулан авч үзээд, бүтээлдээ олон нийтийн дипломат ажиллагааны хэлбэрүүдийг ангилсан нь монгол судлаачдын зүгээс анхны оролдлого юм. Тэрээр олон нийтийн дипломат ажиллагааг “Зөвхөн Засгийн газар хооронд бус, төрийн бус байгууллага, олон нийтийн бие даасан байгууллагуудаар дамжин хэрэгждэг, мөн түүнчлэн Засгийн газрын үзэл бодол, шийдвэр гаргалтанд бие даасан хувийн салбар, байгууллагуудаар дамжуулан нөлөөлдөг талтай”² гээд “Олон нийтийн дипломат ажиллагаа идэвхжиж байгаагийн гол шалтгаан нь технологийн хөгжил дэвшилтэй нягт холбоотой. Технологи хөгжих тусам мэдээлэл илүү нээлттэй болж, тэр хэмжээгээр олон нийтийн сонирхол, оролцоо, үзэл бодлоо илэрхийлэх боломж нь ихэссэн билээ. Мэдээллийн технологи хөгжиж, мэдээлэл нээлттэй, шуурхай болсны ачаар улсын гадаад, дотоод бодлогын хэрэгжилтэд олон нийтийн оролцоо ихэсч, ардчилал хөгжих тусам олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгжүүлэх таатай орчин бүрдэж байна”³ гэж дүгнэжээ.

Олон нийтийн дипломат ажиллагааны талаар судлаачдын анхаарлыг татсан хэд хэдэн өгүүлэл бичсэн, Жоржтауны Их Сургуульд “Олон нийтийн дипломат ажиллагаа” хичээл заадаг Жон Браун “Гадаадын олон нийт рүү чиглэсэн, тухайлбал Фүлбрайтсын боловсрол солилцооны хөтөлбөрөөс эхлээд АНУ-ын гадаад бодлогыг мэдээлэх бүхий л ажиллагаа нь олон нийтийн дипломат ажиллагаа юм” гэжээ.⁴

Түүхэн замналыг нь харахад энэхүү дипломат ажиллагаа нь нэг улсын засгийн газар нөгөө улсын нийт ард иргэдийн хооронд харилцаа холбоо тогтоох хэлбэрээр явагдаж иржээ. Тэгэхдээ, шууд олон нийт рүү чиглэлгүй, харин өргөн хүрээнд нөлөөлж чадах тодорхой хэсэг бүлэг болон хувь хүн рүү чиглэсэн үйл ажиллагааг голлон явуулж иржээ. Өөрөөр хэлбэл, засгийн газраар бус харин ард иргэдээр дамжуулан улс орнууд харилцахыг чухалчилдаг дипломат ажиллагаа юм.

Өнөө үед энгийн ард иргэд, олон түмний санаа бодол, сэтгэгдлийн олон улсын харилцаанд нөлөөлөх нөлөөлөл нь зөвхөн өндөр дээд түвшинд хэрэгжиж байдаг яриа хэлэлцээрийн үр дүнгээс илүү байгаа тул аливаа орны талаарх энгийн иргэдийн ойлголт, тэдэнд

2 Д. Цолмон, Д. Оюунсүрэн, С. Баясгалан, “Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс”, УБ, 2009. х.43

3 Ibid., p. 45

4 <http://publicdiplomacy.org>

төрсөн, хадгалагдсан сэтгэгдэл, хүмүүсийн үзэл бодол, хандлагаар дамжуулан улс орнууд гадаад, дотоод бодлогодоо ямар чиг удирдамж авч, улмаар олон улсын харилцаанд оролцохдоо ямар байр сууринаас хандаж, ямар ач холбогдолтой зүйлсийг анхаарч хэрэгжүүлж буй арга зам, ажиллагааг дипломат ажиллагаандаа тусгахыг судлах нь олон нийтийн дипломат ажиллагааны талаарх судалгааны гол объект юм. Засгийн газрын шийдвэр гаргалтанд олон нийтийн санаа бодол нөлөөлөх явдал нэмэгдэж, тэдний үг яриа, үзэл хандлага нь аливаа улсыг гадаад ертөнцөд таниулах хамгийн чухал гэж дээрх нэр бүхий судлаачид үзэж байна.

АНУ, БНХАУ зэрэг их гүрнүүд гадаад бодлогодоо иргэд хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэн бэхжүүлэх алхам хийснээр хувь хүн, иргэд байгууллагын харилцаа, хамтын ажиллагаа нь улс орнуудын засгийн газар хоорондын харилцаанд эерэгээр нөлөөлдөг болохыг ойлгож, олон нийтийн дипломат ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд ихэд анхаарч байна. Тухайлбал тэд төрөл бүрийн түвшинд энгийн иргэдийн солилцоог эрчимжүүлж байгаа бөгөөд ялангуяа боловсролын салбарт эрдэм шинжилгээний, оюутан сурагчдын, багш эмч нарын болон нарийн мэргэжлийн ажилчдыг харилцан, солилцож арга туршлагаа хуваалцаж байна. АНУ-ын олон салбарт хятад, энэтхэг иргэд идэвхтэй ажиллаж байна.

Олон нийтийн дипломат ажиллагааны үүсэл, түүхэн замналын талаар судлаачид янз бүрээр авч үздэг. Тухайлбал, АНУ-ын судлаач, Николас Ж. Калл *“Public Diplomacy’ Before Gullion: The Evolution of a Phrase”* буюу *“Э. Галлионаас өмнөх Олон Нийтийн Дипломат Ажиллагаа: уг ойлголтын талаарх хувьсал өөрчлөлт”* гэсэн бүтээлдээ энэ талаар бичихдээ *“Үнэн хэрэгтээ ‘олон нийтийн дипломат ажиллагаа’ гэсэн үгийг америкчууд анх гаргаж ирсэн хэрэг огт биш; 1856 онд “Таймс” сэтгүүлийн тэргүүн нүүрэнд энэ үг бичигдэж байсан юм. Ерөнхийлөгч Франклин Пиерсийн⁵ хуурамч хандлагыг шүүмжилж бичсэн тэр өгүүлэлд олон нийтийн дипломат ажиллагаа гэдэг үгийг эелдэг боловсон байдал гэсэн үгтэй ижил*

5 АНУ-ын 14 дэх ерөнхийлөгч Франклин Пиерс (1853-1857) нь Ардчилсан Намаас нэр дэвшиж гарч ирсэн бөгөөд муж улсуудад оргодол боолчуудыг барьж эздэд нь эргүүлж өгч байхыг заасан “Оргодол боолын тухай” Канзас-Небраскагийн хуулийг 1854 онд батлан гаргаснаас болж нэр хүнд нь унаж, сонин хэвлэлүүдэд түүнийг шоглон бичиж байжээ. Умард Өмнөдийн зөрчлийг хурцатгаж, Холбооны эв нэгдлийг ганхуулсан түүнийг дахин ерөнхийлөгчөөр сонгоогүй юм. <http://www.whitehouse.gov/about/presidents/>

утгаар хэрэглэсэн байжээ⁶.” гэжээ.

Олон нийтийн дипломат ажиллагаа гэсэн үгийг одоогийн утгаар анх хэрэглэсэн хүн нь АНУ-ын дипломат ажилтан байсан Эдмунд Галлион ажээ. Тэрээр 1960-аад оны дундуур *олон нийтийн дипломат ажиллагаа* буюу *public diplomacy* гэсэн үгийг анх хэлжээ. 1965 онд АНУ-ын Массачусетс мужийн Бостон хотын ойролцоо оршдог Тафтсын Их Сургуулийн салбар болох Хууль зүй, Дипломат Ажиллагааны Флетчер Сургууль дээр “The Murrow Center of Public Diplomacy” буюу Эдвард.Р. Марроугийн нэрэмжит “Олон Нийтийн Дипломат Ажиллагааны Төв”-ийн нээлт дээр тус их сургуулийн Дипломат Ажиллагааны Флетчер сургуулийн захирал, нэрт дипломатч асан дээрх Эдмунд Галлион “*Олон нийтийн дипломат ажиллагаа*” гэсэн үгийг анх хэлжээ. Тэрээр олон улсын хэмжээнд мэдээллийг түгээх, мөн улс орнууд өөр хоорондоо соёлын харилцаатай байх үйл явцыг илэрхийлэхдээ энэ үгийг хэрэглэсэн түүхтэй ажээ.⁷ Эдвард Р. Марроу⁸ нь 1940–1950 онд АНУ-ын хамгийн нэр хүндтэй сэтгүүлчдийн нэгд тооцогддог бөгөөд дэлхийн II дайны үед Британийн олон нийтийн дипломат ажиллагааны чухал зэвсэг болсон сэтгүүлч гэгдэж байжээ. АНУ-ын 35 дахь Ерөнхийлөгч, Жон Ф. Кеннедийн (1961-1963) засаглалын үед тус улсын олон нийтийн дипломат ажиллагааны талбарыг хариуцан ажиллаж, АНУ-ын Мэдээллийн Агентлагийн захирлын албыг хашиж байсан Эдвард Марроуг орчин үеийн радио телевизийн сэтгүүлзүйн үндсийг тавьсан хүний нэгд зүй ёсоор тооцдог. Тэрбээр “*Ятгаж итгүүлэхийн тулд итгэл төрүүлэхүйц байх ёстой, итгэл төрүүлэхийн тулд үнэмшилтэй байх ёстой, үнэмшилтэй байхын тулд үнэнч шударга байх ёстой*” гэж хэлдэг байжээ.⁹

Тафтсын Их сургуулийн Хууль зүй, Дипломат Ажиллагааны Флетчер Сургууль дээр байгуулагдсан Эдвард Р. Марроугийн нэрэмжит Олон Нийтийн Дипломат Ажиллагааны Төвийн үйл ажиллагааг танилцуулсан товхимолд олон нийтийн дипломат ажиллагааны бодит үүргийг тодорхойлж бичихдээ “*Гадаад бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэхэд олон нийтийн санаа бодол, хандлагыг тусгах, нөлөөлөл нь байх явдал юм*”¹⁰ гэжээ. Өөрөөр хэлбэл гадаад бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэхийн тулд олон нийтийн дипломат

6 <http://en.wikipedia.org/wiki/publicdiplomacy>

7 Д. Цолмон “The US Foreign Policy and Public Diplomacy in the Curriculum of SFS, NUM”, “Олон Улсын Харилцаа” сэтгүүл, 2003. №2. 231(08). х. 33

8 Edward R. Murrow, (1908-1965) <http://en.wikipedia.org/wiki/publicdiplomacy>

9 Edward R. Murrow, (1908-1965) <http://en.wikipedia.org/wiki/publicdiplomacy>

10 <http://www.publicdiplomacy.org/>

ажиллагаагаар дамжуулан олон нийтийн санаа бодол хандлагыг тусгаж, гадаад бодлогын хэрэгжилтэнд нөлөөлөх нь дипломат ажиллагааны үүрэг гэдгийг тэнд онцлон зааж өгчээ.

“*Олон нийтийн дипломат ажиллагаа*” гэсэн үгийг АНУ-д тэр даруй түгээмэл хэрэглэх болсон бөгөөд үүнд гурван шалтгаан байдаг ажээ.

Нэгдүгээрт: АНУ-ын хувьд ЗХУ-ын баримталдаг бодлого болон АНУ-ын мэдээллийн ардчилсан бодит байдал хоёрын хоорондын ялгааг илүү тодорхой болгохын тулд *суртал нэвтрүүлгийн (пропаганда)* ба *сэтгэл зүйн дайралт* зэрэг үгсийн оронд хэрэглэх өөр аятай үг хэллэгийг сонгож олох хэрэгтэй байжээ.

Хоёрдугаарт: 1953 – 1999 оны хооронд үйл ажиллагаа явуулж байсан олон улсын мэдээллийн товчоо буюу АНУ-ын Мэдээллийн Агентлагын зүгээс “*Олон нийтийн дипломат ажиллагаа*” гэсэн үгийг хэрэглэх нь тухайн үедээ гадаад албаны үндсэн ажилтнууд болох дипломатчдын байр суурийг бэхжүүлнэ гэж үзсэн тул уг нэр томьёог тун таатай хүлээж авчээ.

Гуравдугаарт: “*Олон нийтийн дипломат ажиллагаа*” гэдэг үг нь АНУ-ын дипломат ажиллагааны гол цөм болсон улсынхаа алсын хөгжлийн хандлага, саналыг олон улсаар хүлээн зөвшөөрүүлж, дэлхий дахинд АНУ-ын нэр хүнд, байр суурь, нөлөөг бэхжүүлэхдээ олон нийтийн бодол санаанд нөлөөлөх аргыг ашиглах гэсэн зорилготой нь уялдаж байжээ.¹¹

АНУ-ын Мэдээллийн Агентлагын үйл ажиллагааг “Америкийн Дуу Хоолой” радио станцаас давуу гэдгийг нотлон харуулж, түүнчлэн Төрийн Департаментын хариуцдаг соёлын ажиллагааг 1978 онд Олон нийтийн дипломат ажиллагааны хэлтэст нэгтгэснийг зөвтгөхдөө “*Олон нийтийн дипломат ажиллагаа*” гэдэг үгийг мөн хэрэглэх болжээ. Ингээд АНУ-д “*олон нийтийн дипломат ажиллагаа*” гэдэг үг олонтаа хэрэглэгдэх болсон ч зурагтаар шинэ мэдээг цаг алдахгүй авах болж, интернет үүсч, зүүн Европыг бүхэлд нь хамарсан улс төрийн өөрчлөлтөөс үүдэн имиж бүрдүүлэх буюу өөрийн орны талаарх ойлголтыг бусад улсуудад бий болгох, тэдэнтэй мэдээлэл солилцох зэрэг нь олон улсын харилцаанд ач холбогдолтой шинэ үзэгдэл болж байгааг хүйтэн дайны дараах хэдхэн жилд барууны гол улс орнуудад ойлгуулах хүртэл олон улсын хэмжээнд дээрх нэр томьёо нь тэгтлээ түгээмэл хэрэглэгддэг болоогүй байжээ. Британи зэрэг нэлээд олон

11 Nikolas J. Cull. “Public Diplomacy: Lessons from the Past”., Figueroa Press, Los Angeles, 2009;

улсын төрийн албад “Олон нийтийн дипломат ажиллагаа” гэсэн үгийг 1980-аад оноос хэрэглэх болжээ. Ингээд энэ шинэ нэр томъёо нь олон улсын харилцаанд ач холбогдолтой чухал ойлголт болсон байна.

Олон нийтийн (ардын) дипломат ажиллагаа гэсэн нэр томъёо бий болоод дөнгөж хагас зуу орчим жил болж байгаа хэдий ч АНУ, Англи, Нидерланд зэрэг улсад олон нийтийн дипломат ажиллагааны талаарх судалгаа эрчимжиж, нийгмийн олон салбарт уг дипломат ажиллагаагаар дамжуулан олж авсан үр ашгаа хүртсээр байна. Мөн сүүлийн 10-аад жилийн хугацаанд Хятад, Орос, Энэтхэг, Бразил зэрэг орнуудад тус дипломат ажиллагааг эрчимтэй судалж эхлээд байна. Өөрөөр хэлбэл олон нийтийн дипломат ажиллагаа нь олон улсын харилцаа, дипломат ажиллагааг судлаачдын сонирхлыг ихээр татаж байна. Тэдгээрээс томоохон бүтээлүүдийг дурьдвал: АНУ-ын судлаач, Николас Каллын “*The Cold War and the United States Information Agency: American Propaganda and Public Diplomacy, 1945-1989*”; “*Selling America: The Failure of US public diplomacy 1989-2008*”, “Э. Галлионаас өмнөх Олон Нийтийн Дипломат Ажиллагаа: энэ ойлголтын талаарх хувьсал өөрчлөлт” зэрэг хэд хэдэн бүтээл бөгөөд тэрээр олон нийтийн дипломат ажиллагааны онол, түүх, онцлог, түүний элементүүдийн талаар бичжээ. Мөн түүний “*Олон Нийтийн Дипломат Ажиллагаа*” /PD Magazine/ сэтгүүлд олон тооны өгүүллүүд, мөн “*Public Diplomacy: Lessons from the past*” (*Олон Нийтийн Дипломат Ажиллагаа: өнгөрсөн үеэс авах сургамж*) нэртэй эрдэм шинжилгээний бүтээл, Geoffrey Cowan-тай хамтран бичсэн “*Public Diplomacy in a Changing World*” (*Өөрчлөгдөж буй дэлхий ертөнц дэх олон нийтийн дипломат ажиллагаа*) гэдэг бүтээл нь АНУ-ын Улс Төр, Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн сэтгүүлийн тусгай дугаарт 2008 онд хэвлэгдсэн юм.¹² Николас Калл бүтээлүүддээ даяаршлын эрин үед хэрэгжүүлэх ёстой хамгийн чухал нь олон нийтийн дипломат ажиллагаа болохыг онцлон тэмдэглээд, *орчин үеийн олон улсын харилцаанд тун их ач холбогдолтой байж болох энэхүү дипломат ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй*¹³ гэж дүгнэжээ.

Тафтсын Их Сургуулийн Хууль зүй, Дипломат Ажиллагааны Флетчер сургуулийн захирал Алан Хенриксоны 2006 онд хэвлүүлсэн “*What can public diplomacy achieve?*” бүтээлд харилцаа холбооны

12 Special issue of Annals of the American Academy of Political and Social Sciences, March 2008, Volume 616, No. 1.

13 Nicholas J. Cul., “Public Diplomacy: Lessons from the Past”, Figueroa Press, Los Angeles, 2009. p. 7

хувьсал, технологийн хөгжил дэвшлийн ачаар олон улсын харилцааны нөхцөл байдал ихэд өөрчлөгдөж буй өнөө үед олон нийтийн дипломат ажиллагаа чухал болж байгааг онцлоод, түүнийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, амжилтын талаар авч үзжээ. Зөвхөн хоёр улс хоорондоо харилцан ойлголцох төдий бус, олон талаас ойлголцох, ижил өнгө аяс хандлагаар олон улсын харилцааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх нь чухал учраас олон нийтийн дипломат ажиллагаа нь хамгийн оновчтой, зөв болохыг тэрээр уг бүтээлдээ онцолжээ.

АНУ-ын Өмнөд Калифорнийн Их Сургуулийн Олон Нийтийн Дипломат Ажиллагааны Төвийн захирал, Филипп Саяб мөн олон нийтийн дипломат ажиллагааг судалж, *“Public Diplomacy, New media and counterterrorism”*, *“Religion and Public Diplomacy”*, *“Toward a New Public Diplomacy”* зэрэг хэд хэдэн ном туурвиж, эрдэм шинжилгээний олон арван өгүүллүүд бичжээ.

Олон улсын харилцаа судлаачид одоогоор олон нийтийн дипломат ажиллагааны талаарх нэгдсэн тодорхойлолтонд хараахан хүрээгүй байна гэж үзэж болно. Учир нь дипломат ажиллагааг тодорхойлохоосоо тайлбарлах нь илүү ойлгомжтой байдаг бөгөөд хувийн хэлхээ холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн ярилцлагаас эхлээд интернэт, боловсролын солилцоо зэрэг өргөн хүрээнд, өөр өөр арга замаар хэрэгждэг өвөрмөц онцлогтой учраас олон улсын харилцаа, дипломат ажиллагааг судалдаг эрдэмтэд янз бүрээр тодорхойлдог.

Николас Калл *“Олон нийтийн дипломат ажиллагаа гэдэг нь олон улсын байдлыг олон нийтийн оролцоотойгоор зохицуулах гэсэн оролдлого юм”*¹⁴ гэжээ. Түүний бичсэнээр олон нийтийн дипломат ажиллагаа гэдэг нь гадаадын олон нийтэд шууд нөлөөлөх хэлбэрээр явагддаг бөгөөд тэднийг анхааралтай сонсож, хандлага, арга замыг нь аажмаар өөрчлөх, ингэснээр үр дүнд нь хамгийн гол бодлогыг зөв байлгах явдал юм. *Тухайн улсын хувьд гадаад бодлогынхоо чухал элемент гэж үзэж байгаа аливаа асуудлыг анхаарч дэмжих зэргээр олон нийттэй холбоотой ажилладаг дипломат ажиллагаа юм.*¹⁵

Николас Калл олон нийтийн дипломат ажиллагааг тодорхойлохдоо *“Дэлхийн улс орнуудын ард түмэнд нөлөөлөх замаар олон улсын байдлыг зохицуулахын тулд аль нэг Засгийн газар эсвэл байгууллагаас явуулж буй үйл ажиллагааг хэлнэ”* гээд үүнийг бүрдүүлэгч таван чухал элемент байдаг гэж үзжээ. Үүнд:

1. Харилцан сонсох /ОНДА-г үр дүнтэй явуулах үндэс суурь нь/

14 Nicholas J. Cull, “Public Diplomacy: Lessons from the Past”., Los Angeles, 2009

15 *ibid.*,

2. Дэмжих
3. Соёлын дипломат ажиллагаа явуулах
4. Солилцох /солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх/
5. Олон улсын радио телевизээр нэвтрүүлэх¹⁶ зэргийг оруулжээ.

Олон нийтийн дипломат ажиллагаа нь олон түмнээр дамжуулан улс орнуудын хоорондын харилцааг ойртуулж, харилцан ойлголцол, итгэлцлийг бий болгох замаар гадаад бодлогын таатай орчинг бүрдүүлэх зорилго бүхий дипломат ажиллагааны нэг хэлбэр юм. Засгийн газруудаар бус харин ард иргэдээр дамжуулан харилцахыг чухалчилдаг олон нийтийн дипломат ажиллагааг улс төр, эдийн засаг, соёлын гэх мэт дипломат ажиллагааны бусад хэлбэрүүдтэй хослон явуулахад илүү их ач холбогдолтой байдаг. Ялангуяа соёлын дипломат ажиллагаатай нягт холбоотой хэрэгждэг.

Үндэстэн хоорондын харилцан хамаарал гүнзгийрсэн даяаршлын үед олон нийтийн дипломат ажиллагааг идэвхтэй явуулах нь улс үндэстэн хоорондын харилцаанд харилцан ойлголцох найрсаг уур амьсгалыг бий болгож, хоёр орны харилцаа төдийгүй, олон улсын харилцаанд байр сууриа бэхжүүлэх, нэр хүндээ өсгөх зэрэг ач холбогдолтой. Глобал шинжтэй, тулгамдсан асуудлууд, аливаа хямрал, маргааныг тайван замаар шийдвэрлэхэд, мөн улс орнуудын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бэхжүүлэхэд олон нийтийн дипломат ажиллагааны хувь нэмэр асар их юм. Учир нь энэ дипломат ажиллагаа их энгийн явагдах нь элбэг агаад тэвчээртэй сонсох чадвар, дотносох сэтгэл, итгэлцэл, чин сэтгэлийн яриа хөөрөө, нөхөрлөлөөр дамжин үр дүнтэй хэрэгждэг байна.

Олон нийтийн дипломат ажиллагааны гол үүрэг нь олон нийтийн санаа бодол, хүсэл хандлагад нөлөөлөх замаар шийдвэр гаргагчдад хүрч, тэдний үйл ажиллагаагаар дамжуулан улс орны хооронд харилцаа тогтоох, иргэд хоорондын ойлголцлыг бэхжүүлэх, гадаад бодлогын ашиг сонирхлоо бусад улсаар хүлээн зөвшөөрүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх, олон талт харилцааг хөгжүүлэх зэрэг улс төр, эдийн засаг, соёлын дипломат ажиллагааг явуулахад тус дөхөм болох юм. Тийм учраас олон нийтийн дипломат ажиллагаа хэмээх ойлголт, түүний үндсэн чиг хандлага нь олон улсын харилцаанд ихэд нөлөөлж байна. Энэ бол аливаа улсын эрх барих дээд байгууллага буюу засгийн газарт биш харин эгэл жирийн иргэдэд шууд хүрч ажилладаг онцлогтой дипломат ажиллагаа юм. Тэгэхдээ иргэдэд янз бүрийн аргаар хүрч болох бөгөөд тухайлбал нэг жижиг хотод Энх тайвны

16 Ibid.,

корпусын шугамаар очиж ажиллах хамгийн энгийн аргаас эхлээд хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдээр дамжин томоохон аргаар олон түмэнд хүрч болно. Сүүлийн арга болох хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах нь олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгжүүлэх амин судас болоод байна. Радио телевизийг ухаалгаар ашиглаж буй орнуудын хувьд улс төрийн гол зэвсэг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл байсаар ирсэн билээ.

Техник технологийн хөгжил хүн төрөлхтөний түүхэнд урьд өмнө байгаагүйгээр илүү хурдацтай дэвшин хөгжиж буй өнөө үед сансрын хиймэл дагуулын тусламжтайгаар төрөл бүрийн сувгийг хүлээн авч, интернетээр дамжуулан богино хугацаанд асар их мэдээллийг солилцох боломжтой болсноор улс хоорондын харилцаа эрс идэвхжиж байгаа тул техник технологийн дэвшил олон нийтийн дипломат ажиллагааг эрчимтэй явуулах гол түлхэц болж, олон улсын харилцаанд нөлөөлөх нь улам нэмэгдэж байна. Үүнийг анзаарсан улс гүрнүүд олон нийтийн дипломат ажиллагааг илүү анхаарч, гадаад дотоод бодлогоо хэрэгжүүлэхдээ ашиглах болсон нь зүй ёсны үзэгдэл юм.

Олон улсын харилцаанд улс орнуудын гадаад бодлогод чухал байр суурь эзлэх болсон олон нийтийн дипломат ажиллагааг гүнзгийрүүлэн судалж, үр дүнтэй хэрэгжүүлж байгаа орны туршлагаас суралцах; дипломат ажиллагааг онол, практикийн талаас үүсэл, хөгжлийн чиг хандлагатай нь холбон тодорхойлох, ач холбогдол, онцлогийг Монгол мэт багавтар улсын гадаад бодлогын хэрэгжилтэд хэрхэн анхаарч болохыг судалж, энэ чиглэлийн судалгааг шинжлэх ухааны эргэлтэд оруулах нь чухал.

Иймд олон нийтийн дипломат ажиллагааг судалж, Монгол улсад тохирох, тус болох хэлбэрийг сонгон хэрэгжүүлснээр манай улсын нэр хүнд, байр суурь олон улсын хэмжээнд бэхжих бөгөөд цаашлаад олон нийтийн дипломат ажиллагааг гадаад бодлогоо үр дүнтэй хэрэгжүүлэх нэг арга ажиллагаа болгож болох юм. Гадаад бодлогын хэрэгжилт дипломат ажиллагаагаар илрэн гарч, үр дүн нь түүнээс шалтгаалдаг учраас XXI зууны хамгийн чухал дипломат ажиллагааны нэгд зүй ёсоор тооцогдож буй олон нийтийн дипломат ажиллагааг үл хэрэгсэх, үл мэдэх нь учир дутагдалтай юм.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Edward R. Murrow, (1908-1965) <http://en.wikipedia.org/wiki/publicdiplomacy>
2. J. C. Johari, “International Relations and Politics” (Theoretical Perspective in the Post-Cold War Era)., New Delhi, Third edition, 2009;
3. Nikolas J. Cull, “Public Diplomacy: Lessons from the Past”., Figueroa Press, Los Angeles, 2009;
4. Special issue of *Annals of the American Academy of Political and Social Sciences*, March 2008, Volume 616, No. 1.
5. Д. Цолмон “The US Foreign Policy and Public Diplomacy in the Curriculum of SFS, NUM”, “Олон Улсын Харилцаа” сэтгүүл, 2003. №2. 231(08).
6. Д. Цолмон, Д. Оюунсүрэн, С. Баясгалан, “Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс”., УБ, 2009.
7. <http://www.whitehouse.gov/about/presidents/>
8. <http://en.wikipedia.org/wiki/publicdiplomacy>